



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/685

Ховд

Цэргийн дүйцүүлэх албаны
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 30.3, 30.4, 33 дугаар зүйлийн 33.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын 4.1, 4.2, 4.4, 4.5 дугаар заалт, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам” ын 4.1.8, 4.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн 2 дахь жилдээ хааж байгаа иргэдтэй “Тусгай үүргийн бэлтгэл шат”-ны, эхний жилдээ алба хааж буй иргэдтэй “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтуудыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн чанарын өндөр түвшинд зохион байгуулж явуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д даалгасугай.

2.Сургалтыг явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэхийг Зэвсэгт хүчний 123 дугаар анги /хурандаа М.Болдбаатар/-д, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг тус ангийн байнгын байрлалд 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр бэлэн байлгахыг холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний тоог 1 дүгээр, сургалтад зарцуулах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Сургалтанд зарцуулах 5575286 төгрөг /Таван сая таван зуун далан таван мянга хоёр зуун наян зургаан/-ийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс

Zax A/685 Ch

02 03380

гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


5. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдтэй явуулсан сургалтын дүнг гаргаж, танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга / хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн засаг даргын 2019 оны 10 дугаар
сарын 24-ний өдрийн А/685 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



СУРГАЛТАНД ОРОЛЦОХ ХҮНИЙ ТОО

Д/д	Сумын нэр	Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтад хамрагдах	Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтад хамрагдах
1	Жаргалант	3	13
2	Дуут	6	
3	Ховд		
4	Эрдэнэбүрэн		
5	Мянгад	9	2
6	Буянт		5
7	Дөргөн	2	4
8	Дарви	5	5
9	Зэрэг	2	6
10	Манхан		6
11	Чандмань	9	3
12	Мөст	4	
13	Цэцэг	9	5
14	Мөнххайрхан		5
15	Үенч	3	
16	Алтай	7	1
17	Булган	1	5
	Нийт	60	60
	Бүгд		120

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/685 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААГЧИДТАЙ ЯВУУЛАХ
СУРГАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО

Д/д	Сургалтанд шаардагдах зардлын нэрс	Төлөвлөсөн мөнгөн дүн төгрөгөөр	Тайлбар
1	Сургалтанд оролцох бэлтгэл үүрэгтэн хоолны зардал 120 хүн *7 хоног*хээрийн нөхцөлд өдөрт 3 удаа хооллоно.	4348260	
2	Түлш 1 амаар 7 хоног=0,25 куб/метр*130 000 төг /КО-75 тогоо/	227500	
3	Сургалтын бичиг хэргийн зардал: 120 хүний хичээлийн дэвтэр, үзэг, харандаа, хичээлийн хуваарь, сургалтанд хэрэглэх материал, шохой, бичгийн цаас	495000	
4	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг Жаргалант суманд тээвэрлэн авчрах, буцааж хүргэх зардал	504526	
Дүн		5575286	

СУРГАЛТАНД ХЭРЭГЛЭГДЭХ БИЧИГ ХЭРГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Бичиг хэргийн хэрэгслэл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо /ш/	Бүгд үнэ
1	Дэвтэр /багш /	ш	2500	6	15000
2	Дэвтэр	ш	1200	120	144000
3	Бал, харандаа, баллуур	ш	2350	120	282000
4	Шохой	хайрцаг	3000	2	6000
5	Бичгийн цаас	боодол	12000	4	48000
Бүгд					495000

**СУРГАЛТАНД ОРОЛЦОХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ХООЛНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	материалын нэр	хэмжих нэгж	тоо хэмжээ	хугацаа	хүний тоо	нийт дүн	нэг бүрийн үнэ	нийт үнэ
		1 өдөрт 1 хүнд ногдох		7 өдөр 1 хүнд ногдох				
1	мах	кг	0.42	2.94	120	352.8	7000	2469600
2	талх	кг	0.6	4.2	120	504	1200	604800
3	цагаан будаа	кг	0.06	0.42	120	50.4	2500	126000
4	бусад будаа	кг	0.04	0.28	120	33.6	3500	117600
5	гоймон	кг	0.04	0.28	120	33.6	1800	60480
6	гурил	кг	0.1	0.7	120	84	1200	100800
7	ургамалын тос	кг	0.025	0.175	120	21	6000	126000
8	масло	кг	0.03	0.21	120	25.2	4500	113400
9	сахар	кг	0.07	0.49	120	58.8	2200	129360
10	цай	кг	0.004	0.028	120	3.36	11000	36960
11	давс	кг	0.025	0.175	120	21	5000	105000
12	төмс	кг	0.35	2.45	120	294	600	176400
13	байцаа	кг	0.1	0.7	120	84	700	58800
14	манжин	кг	0.02	0.14	120	16.8	600	10080
15	лууван	кг	0.04	0.28	120	33.6	600	20160
16	сонгино	кг	0.04	0.28	120	33.6	2500	84000
17	хоол амтлагч	кг	0.003	0.021	120	2.52	3500	8820
БҮГД								4348260

Тайлбар: Монгол Улсын Засгийн Газрын 2006 оны 5 дугаар сарын 10-ны 103 дугаар тогтоолын дагуу 1 хоногийн цэргийн алба хаагчийн хүнсний нормыг үндэслэж, хоолны зардлыг тооцов. /хуурай хэрэглэлийн зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 10 дугаар сарын 08-ны өдөр гаргасан үнэлгээгээр тооцов/

ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААЖ БУЙ ИРГЭДИЙГ
ЖАРГАЛАНТ СУМАНД ТЭЭВЭРЛЭН АВЧРАХ, БУЦААЖ ХҮРГЭХ ШТМ-ЫН
ТООЦОО

Д/Д	сумдын нэр	аймгийн төв хүртэлх зай км-р	зарцуулах штм	тайлбар
1	Дуут	61	12749	
2	Мянгад	36	7524	
3	Буянт	23	4807	
4	Дөргөн	98	20482	
5	Дарви	213	44517	
6	Зэрэг	146	30514	
7	Манхан	86	17974	
8	Чандмань	144	30096	
9	Мөст	187	39083	
10	Цэцэг	233	48697	
11	Мөнххайрхан	146	30514	
12	Үенч	340	71060	
13	Алтай	318	66462	
14	Булган	383	80047	
	БҮГД:	2414	504526	

-оОо-